

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй торгууд судлалд хамаарах эх хэрэглэгдэхүүний тойм

Хэл зохиолын хүрээлэнгийн үе үеийн эрдэмтэд 1952-1992 оны хооронд жил бүр Монгол улсын аймаг, сумдаар хээрийн шинжилгээний анги илгээж монгол аман зохиол, нутгийн аялгууг судалсны үр дүнд монгол хэл бичиг, аман зохиол, түүх угсаатны зүйн холбогдолт баялаг эх хэрэглэгдэхүүн цуглуулсан билээ. Эдүгээ Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй 450 хавтас бүхий хээрийн шинжилгээний ангийн тайлан, гар бичмэл эх хэрэглэгдэхүүнээс шүүн үзэж торгууд судлалд хамаарах хэдэн материал олсноо бид тойм байдлаар танилцуулахаар бэлдлээ.

Юун түүрүүн бид Ховд аймгаар явсан шинжилгээний ангийн тайлан материалын тоог гарган сан хөмрөгт хадгалагдаж буй нийт тайлан² материалтай харьцуулж, тоон үзүүлэлтээр³ харууллаа. Үүний дараа хавтаст материалуудын дугаар, хээрийн шинжилгээгээр явсан он, нэр зэргийг жагсаан хүснэгтэллээ⁴. Энд анхаарууштай нь, сан хөмрөгт хадгалагдаж буй хэд хэдэн тайлан материалд шинжилгээний ангийн бүрэлдэхүүн, гишүүдийн нэр зэрэг нь бичигдээгүй байхаас гадна зарим эх хэрэглэгдэхүүнд үүсгэгчийн нэр, нас, харьяаны талаар дурдалгүй орхисон, мөн олон оныг дамнан хадгалагдахдаа гээгдэн үрэгдсэн нь ч тохиолдож байна.

Монгол улсын угсаатны бүлгүүд дундаас торгууд түмэн нь Ховд аймгийн Булган сумд нутаглаж буйг Монгол улсын Үндэсний статистикийн хорооны тайлан үзүүлэлтээс харж болно⁵. Иймд Ховд аймгаар явсан шинжилгээний ангийн нийт тайлан материал доторх маршрутыг ажиглаж, Булган сумын нутагт 1958, 1965, 1977, 1987 онуудад очсон 4 хавтаст материалыг шүүн олж, харьцуулсан тоон үзүүлэлтийг⁶ гаргалаа. Ингээд торгууд судлалд хамаарах эх хэрэглэгдэхүүнийг Ховд аймгийн Булган сумаар явсан шинжилгээний ангийн дээрх 4 тайлан мэдээнээс шүүн үзсэнээ та бүхэнд тоймлон хүргэе.

¹ ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторийн эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан М.Билгүүнчимэг

² Алимаа А, Катуу Б нар., *Монгол аман зохиол, нутгийн аялгууны хөмрөгийн бүртгэл*. I боть. УБ., 2004. 25-р тал.

*Хөмрөгийн бүртгэлд дурдсанаар нийт 35 анги хээрийн шинжилгээгээр явсан хэмээжээ.


³ Хүснэгт 1

⁴ Хүснэгт 2

⁵ <https://www.nso.mn/mn>

*Монгол Улсын Засгийн газраас тусгайлан захиалж Шинжлэх ухааны академийн Түүх археологийн хүрээлэнгээс хэрэгжүүлсэн “Монголчуудын гарал, угсаатны бүрэлдэхүүн” шинжлэх ухаан технологийн төслийн үр дүн, ангиллын дагуу 2020 онд явуулсан хүн ам, орон сууцны ээлжит тооллогоор Монгол улсад 30 угсаатны бүлгээс бүрдсэн Монгол үндэстэн, 2 угсаатны бүлгээс бүрдсэн Түрэг үндэстэн болон бусад үндэстэн, угсаатнууд оршин сууж байна гэж үзжээ. https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Undes_ugsaa_2020.pdf&ln=Mn

⁶ Хүснэгт 3




Хүснэгт 1.

**ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй
Ховд аймгийн хавтаст материалын жагсаалт**

№	Хавтасны дугаар	Он	Хавтаст материалын нэр
1	1	1958	Ховд, Увс аймгаар явсан хээрийн шинжилгээний ангийн тайлан материал Шинжилгээний ангийн ахлагч Г.Ринчинсамбуу
2	4	1962	Ховд аймгийн захчин аялгууны материал цуглуулсан урьдчилсан товч тайлан Шинжилгээний ангийн ахлагч Ж.Цолоо
3	27	1987	Ховд аймагт ажилласан шинжилгээний ангийн тэмдэглэсэн эх хэрэглэгдэхүүн
4	143	1965	Ховд, Увс, Баян-Өлгий аймагт явсан хам шинжилгээний ангийн тайлан
5	149	1967	Увс, Ховд аймгийн шинжилгээний ангийн тайлан Шинжилгээний ангийн ахлагч Ж.Цолоо
6	150	1967	Увс, Ховд аймгийн шинжилгээний ангийн тайлан Шинжилгээний ангийн ахлагч Ж.Цолоо
7	180	1977	Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймагт ажилласан шинжилгээний ангийн тайлан Шинжилгээний ангийн ахлагч У.Загдсүрэн
8	181	1977	Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймагт ажилласан шинжилгээний ангийн тайлан Шинжилгээний ангийн ахлагч У.Загдсүрэн
9	189	1975	Ховд, Баян-Өлгий аймагт явсан шинжилгээний ангийн аман зохиолын цуглуулга
10	203	1965	Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн шинжилгээний ангийн тайлан

Хүснэгт 2.



Хүснэгт 3.

1958 оны 1 дугаар бүхий хавтаст материал⁷ нь монгол бичгийн таталган, кирилл, латин гар бичмэл хийгээд кирилл бичгийн машинаар бичигдсэн 118 нүүр хуудас эх хэрэглэгдэхүүнээс бүрдэж байна. Ховд, Увс аймагт нутгийн аялгуу, аман зохиол,

⁷ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас №1 1958 онд Ховд, Увс аймгаар явсан хээрийн шинжилгээний ангийн тайлан материал.

үндэстнийг судлахаар 1958 оны 5-р сарын 25-аас 8-р сарын 10-ыг хүртэл явсан шинжилгээний ангийн энэхүү тайлан материалд төслийн зардал, шинжилгээний ангийн ажиллах арга журам, тогтоол №7/17 зэргийг хавсаргажээ. Ховд аймгийн Мянгад, Буянт, Дуут, Мөнххайрхан, Манхан, Алтай, Үенч, Булган сум; Увс аймгийн Малчин, Хяргас, Тариалан, Давст, Туруун, Өндөрхангай, Өмнөговь зэрэг 15 сумаар аялах замын маршрутыг хавсаргаж, түүх соёлын үнэт бичиг дурсгалын зүйлийг цуглуулахаар төлөвлөсөн байна. Шинжилгээний анги 8 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд аман зохиолыг ахлагч Г.Ринчинсамбуу, үндэстний судлалыг С.Бадамхатан, нутгийн аялгууг Э.Вандуй, аман зохиол болон орон нутгийн архивыг Ө.Чимэд, аман зохиол цуглуулгыг М.Шинэхүү, нутгийн аялгуу болон аман зохиол цуглуулах ажлыг оюутан Ж.Цолоо, н.Цогтоо нар тус тус хариуцан Сумьяа ГАЗ-51 машиныг жолооджээ. Нутгийн аялгуу судлалын тайланд эгшиг авиа, гэр, мал аж ахуй, ураг төрөлтэй холбоотой үг хэллэгийг зүйлчлүүлэн хувааж жагсаан бичжээ. Мөн үгийн зүйд тийн ялгал, хамаатах ёс, ганц олон тоо, төлөөний үг, үйлийн нөхцөл зэргийг бичсэн байна.

1965 оны 143 дугаар бүхий хавтаст материал⁸ нь монгол бичгийн таталган, кирилл гар бичмэл хийгээд кирилл бичгийн машинаар бичигдсэн 126 нүүр хуудас эх хэрэглэгдэхүүнээс бүрдэж байна. 1965 оны 9-р сарын 3-аас 11-р сарын 3-ыг хүртэл Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудад 2 сарын хугацаатай ажилласан хам шинжилгээний ангийн энэхүү тайлан материалд хүрээлэнгээс батлагдсан арга зүйн ёсоор монгол ардын тууль, туульч М.Парчингийн тухай, үлгэр, дуу, ардын аман зохиолын бусад төрлийг сурвалжлан цуглуулж, баруун монгол дуунуудыг угсаатны бүлгээр гаргасан бүртгэлийг хавсаргажээ. Тайланг ЭША Б.Лувсан бичсэн бөгөөд Ховд аймгийн Дарви, Мянгад, Эрдэнэбүрэн, Булган зэрэг 7 сум, Баян-Өлгий аймгийн Толбо, Ногооннуур зэрэг 4 сум, Увс аймгийн Бөхмөрөн, Тэс, Сагил, Хяргас, Өмнөговь зэрэг 10 сум, бүгд 21 сум нэгдлийн нутгаар 6000 км аялж ардын аман зохиол сурвалжлан судалсан байна. Үүнд, тууль 13, үлгэр домог 32, туульчдын намтар 17, ардын дуу 250, ерөөл, магтаал 34, хуримын ёс журам 1, оньсого, зүйр цэцэн үг, ардын жүжиг наадам, түргэн хэллэг зэрэг аман зохиолын бусад жижиг төрөл зүйлийг оролцуулан нийтдээ 60 шахам хэвлэлийн хуудас хэрэглэгдэхүүн цуглуулснаа дурджээ. Тус шинжилгээний анги нь баяд, өөлд, мянгад, торгууд, дөрвөд, хотон, захчин дууны талаар нэлээд цуглуулга хийж 220 нэр төрлийг гар бичмэлээр тэмдэглэн авчээ. Эдгээрээс торгуудын 18 дууны жагсаалтыг сийрүүлбэл, “Сантайлингийн ногоо”, “Харгай Дүнгэйн алим⁹”, “Сарлай долоон бургасан”, “Хөх уулын шилд”, “Бүрээгэн аман тамгатай”, “Цагаан саарал морин”, “Сайхан хангайн буга”, “Баатар бэйлийн унаган”, “Өндөр ширээтийн бараан”, “Эрвэн жороо бор”, “Зэкүү сайхан зээрд”, “Эрвэгэр зээрд морин”, “Хилэн сайхан хар”, “Мөөгийн эхэн шилд”, “Саяг саяг саарал”, “Цагаан цоохор морь”, “Бардаанаг баатар” хэмээх түүхэн дуу болон “Бууржийн эхэн шилд” хэмээх шастир дуунууд байна.

⁸ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас №143 1965 онд Ховд, Увс, Баян-Өлгий аймагт явсан хам шинжилгээний ангийн тайлан.

⁹ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас №143 Монгол бичгээр татлан бичсэн эх хэрэглэгдэхүүн 108-р тал.

1977 оны 180 дугаар бүхий хавтаст материал¹⁰ нь кирилл бичгийн машин болон гар бичмэлээр бичигдсэн 147 нүүр хуудас эх хэрэглэгдэхүүнээс бүрдэж байна. Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгуудад 46 хоногийн хугацаатай ажилласан энэхүү тайлан материалд шинжилгээний ангийн бүрэлдэхүүн, зорилго, маршрут, шинжлэх ухааны суртал нэвтрүүлэг, төсөв зэргийг дурдаад, мөн цуглуулсан эх хэрэглэгдэхүүнийхээ талаар бичсэн 3 төрлийн тайланг нэмэн хавсаргажээ. Говь-Алтай аймгийн Жаргалан, Баян-Уул, Дарви, Тонхил, Төгрөг, Алтай, Цээл, Цогт, Эрдэнэ, Ховд аймгийн Алтай, Үенч, Булган, Эрдэнэбүрэн, Манхан, Цэцэг, Мөст, Баян-Өлгий аймгийн Булган, Бугат, Алтай, Буянт зэрэг 20 орчим сум нэгдлийн нутгаар зохих маршрутын дагуу 6000 км аялж, аман зохиол, ардын урлагийн зүйлийг сурвалжлан судалсан байна. Шинжилгээний анги 6 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд ардын аман зохиолыг ахлагч У.Загдсүрэн, Д.Өлзийбаяр, В.Мягмарсүрэн нар, ардын дуу хөгжмийг Ж.Энэбиш, ардын гар урлал, уран дархны зүйлийг Л.Сономцэрэн, ном судрыг У.Загдсүрэн, Д.Өлзийбаяр нар тус тус хариуцан С.Цагаандалай ГАЗ-66 машиныг жолоодсон байна. Дээр дурдсанчлан тус хавтаст материалд аман зохиолын болон ардын дуу хөгжмийн, ардын гар урлалын гэсэн гурван төрлийн хавсралт тайлан бий тул бид торгуудын судлалд хамаарах эх хэрэглэгдэхүүнийг тус тусад нь шүүн үзлээ. Тус шинжилгээний анги нь 20 гаруй сумаар явахдаа тухайн нутагт дэлгэрсэн аман зохиолыг сурвалжлан цуглуулсны зэрэгцээ монгол ардын аман зохиолын нийт төрөл зүйлийг нэгэн адил анхааран ажилласан байна. Цуглуулгыг төрөл зүйлээр жагсаавал ардын дуу 300, үлгэр 15, тууль 3, ерөөл магтаал 13, домог хууч яриа 12, оньсого зүйр цэцэн үг 120, зан үйлийн холбогдолт аман зохиол 11, нийт 473 ширхэг 20 орчим хэвлэлийн хуудас материал болжээ. Уг материалуудыг шүүн үзээд бид хуучнаар торгуудын Мишигдорж вангийн хошуу, одоогийн Ховд аймгийн Булган сумын 4-р багийн харьяат 85 настай морин жилтэй эрэгтэй, урлагийн ажилд 47 жил оролцож яваа хошууд илхэн Магсарын Пүрэвжал¹¹ гуай Жангарын туулийн “Хаан Сырийн бүлэг¹²”-ийг хэлж соронзон хальсанд шингээснийг¹³ 26 нүүр хуудсанд багтаан кирилл гар бичмэлээр тус шинжилгээний ангийн гишүүн В.Мягмарсүрэн буулган бичсэн эх хэрэглэгдэхүүнтэй танилцлаа. “Хан Сырийн бүлэг”-т муу санаат Орно Улаандайд Хаан Сыр хэмээх эр зоригт баатар алуулах боловч Арслангийн улаан Хонгорын хүчээр дахин амьдарч хар мангастай байлдан Мөндөл гоо хатнаа авч Жангарын 18 баатрын нэг болж буй үйл явдал гарна.

¹⁰ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас №180 1977 онд Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймагт ажилласан шинжилгээний ангийн хэрэглэгдэхүүн.

¹¹ Торгуудын өвлөн уламжлагч ардын дууч, ерөөлч, магтаалч, бийч, жангарч, хөгжимчин Магсарын Пүрэвжал (1892-?) нь Вангийн торгууд нь Манжийн захиргааны үед “Вангийн чуулган тамгатай” таван сумд хуваагдан одоогийн Ховд аймгийн Булган сумд нутаглаж, чуулганыг Вангийн торгуудын найм дахь үеийн жүн ван Мишигдорж захирч байв. Мишигдорж вангийн отгон хөвгүүн Ёнгуу (Ёнгрундорж) тайжийн ганц охин Ж.Лхамжав гүнж өдгөө 83 настай бөгөөд Улаанбаатар хотноо ажиллаж, амьдарч байна.

<http://unenmedee.mn/1fa> Трамп Төмөрөө

*Эх сурвалж: “Монголын үнэн” сонин №015/24546/

¹² У.Загдсүрэн нар уг бүлгийг Унгар улсад хэвлүүлсэн нь жангар судлаачдын анхаарлыг татаж судлагдахуун болон ашиглагдсаар байгаа билээ.

*U.Zagdsuren (MPR), *Regions of Spreading of the Epic Work “Djangan”*.

¹³ ХЗХ-ийн сан хөмрөгт хадгалагдаж буй 574-В-3 дугаартай уг соронзон хальс элсэн төдийгүй, уншигч төхөөрөмжийн хурд тохирохгүйн тул бичлэгийг уншуулах боломжгүй байна.

Жангарын энэхүү бүлэг нь тухайн үеийн цоо шинэ олдвор болсон байна. Мөн Пүрэвжал гуай “Жангарын тууль”-ийг өөрөө яаж сурсан тухайгаа, торгуудын Мишигдорж вангийн хошуунд хэрхэн хайлж байсан талаар төдийгүй Жангарын 8 боть номыг авчирсан ч үрэгдүүлсэн тухай, Орчлонгийн сайхан Миньяны бүлэгтэй ном өөрийнх нь ах Тогтбатад байсан зэрэг бичмэл Жангар байсны баталгаа болох яриаг 1977 оны хальсанд бичүүлж үлдээснээрээ судалгааны ач холбогдолтой юм. Ховд аймгийн Булган сумын торгууд эрэгтэй Б.Жимбээ нь “Хүрэн халзан морьтой Хүрэлдэй мэргэн баатар¹⁴” хэмээх туулийг хэлж бичүүлсэн ч хавтаст материалд тэмдэглэгдээгүй үлджээ. Хөгжим судлаач Ж.Энэбишийн бичсэн ардын дуу хөгжим цуглуулгын тайланд хөдөлмөрийн дохиол-аялга, ардын урт богино дууны ая, туульсын хөгжим, ардын дан хөгжим, шашны хөгжмийн талаар тэмдэглэжээ. Нэр дурдсан гурван аймагт 46 хоног ажиллахдаа 100 гаруй хүнтэй уулзаж, ардын хөгжмийн судлалаар 250 ая дууг 1500м хальсанд хурааж, түүнийгээ бүртгэн карталж, заримынх нь аяыг ноот бичгээр тэмдэглэсэн байна. Тухайлбал, Жангарын тууль болон Алтайн магтаалын аяыг дээр дурдсан өндөр настан, уран сайханч Магсарын Пүрэвжал гуайгаас сурвалжлан ноотлон буулгаснаа тайландаа дурджээ. Тус шинжилгээний ангийнхан ардын гар урлалын талаас авдар сав хээлдэг шивээс загвар 12, ардын урлагийн холбогдолтой гар зураг 24, урианхайн мааг гутлын эсгүүр 3, тамганы зураг 36, эмийн зураг 12, ардын урлагийн холбогдолтой гэрэл зураг 43-ыг авч ирснээс гадна баг, балин, дүлцэн, жанхар, зүмбэр зэрэг урлалыг хийдэг аргуудыг судлан, мөн зургийн дэвсгэр цардах, бийр хийх, будаг найруулах, хар зураг татах зэрэг 10 гаруй хэвлэлийн хуудас хэрэглэгдэхүүн бичиж иржээ. Ховд аймгийн Булган сумын 66 настай Шилгийн Жамба “Цаст уулын цагаан арслан” гэдэг домгоос сэдэвлэн авдрын нүүрэнд арслан зурж байсан бөгөөд “Цаст уулын цагаан арслангаас хүчтэй юм байдаггүй” гэж хөгшид ярилцдаг талаар хуучилжээ. Гэрт муу юм оруулахгүй гэж ингэж хээлж байсан нь монголчуудын хувьд хээ угалз нарийн утга учиртай байсны илэрхийлэл билээ. Мөн тус ангийн ховор ном судар сурвалжилсан тайланд Ховд аймгийн Булган сумын Аюушийн Шаравас монгол ном 8, тод ном 10, бүгд 18 ширхэг номыг солилцооны журмаар авч ирснийг тэмдэглэсэн байна. Уг ном, судрын нэрсийг жагсаан тайланд хавсаргажээ. Мөн шинжилгээний ангийнхан монгол ном 25, тод үсгийн ном 18, төвөд ном судар 2000 орчмыг олж ирснээс судалгааны хэрэгцээ зэргийг харгалзан ЭША Л.Хүрэлбаатарын саналын дагуу 39 ширхэг ном буюу 2932 хуудас хэрэглэгдэхүүнийг хүрээлэнгийн төвөд номын хөмрөгт хадгалуулсан байна.

1987 оны 27 дугаар бүхий хавтаст материал¹⁵ нь кирилл бичгийн машин болон гар бичмэлээр бичигдсэн 199 нүүр хуудас эх хэрэглэгдэхүүнээс бүрдэж байна. 1987 оны 4-р сарын 17-оос 5-р сарын 20-ыг хүртэл Ховд аймагт 32 хоногийн хугацаатай ажилласан шинжилгээний ангийн энэхүү тайлан материалд тус аймгийн захчин, торгууд, мянгад

¹⁴ ХЗХ-ийн сан хөмрөгт хадгалагдаж буй 575-А-1 дугаартай уг соронзон хальс элсэн төдийгүй, уншигч төхөөрөмжийн хурд тохирохгүйн тул бичлэгийг уншуулах боломжгүй байна.

¹⁵ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас №27 1987 онд Ховд аймагт ажилласан шинжилгээний ангийн тэмдэглэсэн эх хэрэглэгдэхүүн.

угсаатны бүлгийн үлгэр тууль, ардын дуу, домог, зан үйлийн холбогдолт аман зохиолыг сурвалжлан цуглуулж, цаашид тавих санал болон лекц сурталчилгаа хийсэн тухайгаа хавсаргажээ. Ховд хот, Алтай, Үенч, Булган, Манхан, Мянгад зэрэг сумдад ажиллахдаа С.Баянцагаан монгол бичиг, тод, төвөд үсгээр бичсэн ном сурвалжилж, С.Соронзонболд соронзон хальсанд бичлэг хийх, түүнийг цаасанд буулгах зэрэг ажлыг голлон гүйцэтгэжээ. Б.Катуу Мянгадаас бусад сум руу албан ажлын улмаас явж чадаагүй байна. Тайланг ЭША Д.Өлзийбаяр бичсэн бөгөөд тус шинжилгээний ангийн бүх ажилтан аман зохиол цуглуулах ажилд жигд оролцсоноор тууль 3, үлгэр 4, ерөөл магтаал 16, домог хууч яриа 13, оньсого 30, зүйр цэцэн үг 5ш, ардын дуу 126-г сурвалжилжээ. Иймд бид тайланд хавсаргасан гар бичмэл эх хэрэглэгдэхүүнээс Ховд аймгийн Булган сумын нутагт холбогдох материалуудыг шүүн үзэж, торгууд ардын дууны 78 нэрийг, дуулж тэмдэглүүлсэн үүсгэгчийн 26 нэрийн хамт жагсаан бичлээ.

- Ховд аймгийн Булган сумын 4-р бригадын 95 настай эрэгтэй, вангийн торгуудын дууч, ерөөлч Магсарын Пүрэвжал “Хилэн хамбайн хот”, “Бурам хааны бургас”, “Зээ түмэн наст”, “Шаарын өндөр мод¹⁶”, “Галданбай баатар”, “Тоорой гэдэг мод”, “Гэмгүй” зэрэг ардын дуу болон “Аялгат их агсал¹⁷” хэмээх торгууд биелгээний үгийг хэлж бичүүлжээ. Мөн “Алтайн аргал”, “Хилэн сайхан хар”, “Хөнтөргөнт хөхөг”, “Зуны дэлгэр сар”¹⁸ зэрэг дууг тэмдэглүүлсэн нь төрөлжүүлэн ангилсан эх хэрэглэгдэхүүн дунд тохиолдож байна.
- Ховд аймгийн Булган сумын 1-р бригадын 72 настай эрэгтэй, хошууд торгуудын дууч Мөргүүлчийн Пагма 1987 оны 4-р сарын 30-нд “Шанхагтайхан шарга” хэмээх найрын эхэнд ая барьдаг дуу, “Огторгуйд гарсан солонго”, “Мөнгөн тахтай жороо бор”, “Харагдагч уул”, “Аруу аруу газар” зэрэг дууг судлаач Соронзонд тэмдэглүүлжээ. Мөн “Найман сарын намч”, “Алтай нуурын ус”, “Хангайн буурал морь”, “Дааганд нь дасгасан дархан халиун”, “Тарган бор”, “Цагаан уулын орой”, “Зэргээн ангир хулс”, “Шилийн хөх начин шонхор”, “Эвийн эхэн шил”, “Зуны сайхан дэвээ”, “Сал тохойн мод”, “Эрвэн жороо бор”, “Алтан Богдын орой¹⁹” зэрэг дууг тэмдэглүүлсэн нь төрөлжүүлэн ангилсан эх хэрэглэгдэхүүн дунд тохиолдож байна.
- Ховд аймгийн Булган сумын “Жаргалын зам” нэгдлийн 5-р бригадын малчин, 71 настай эрэгтэй, бэйлийн торгуудын дууч Чимэдийн Риймэд 1987 оны 4-р сарын 20-нд “Дөрвөн

¹⁶ Магсарын Пүрэвжал гуайн өөрийнх нь зохиосон дуу хэмээжээ.

<https://www.polit.mn/a/89889> Ардын дуу сонирхон судлагч Б.Алтанхуяг

*Эх сурвалж: “Зууны мэдээ” сонин № 112 (6589) 2021.6.4

¹⁷ Магсарын Пүрэвжал гуай Их агсал, Бага агсал, Хэлхээ агсал, Жудар, Эрээн хавирга, Хүрэн торгот, Ховог, Цацал, Савардан зэрэг торгууд биелгээг өвлөн уламжилсан давтагдашгүй бийч байжээ. Мөн “Шаргын шаргын жороо”, “Жаавай”, “Таван сүрэг”, “Найман гуа арслан”, “Сүрэн нэртэй долоо” зэрэг олон арван дууг зохиосон хэмээжээ. <http://dundgovi.mn/1286.html>

*МЗЭ-ийн шагналт зохиолч Их Гулзат Дагвын Жүгдэрбарамын “Торгуудын соёлын өвийг тээгч, түгээн дэлгэрүүлэгч” дурсамж тэмдэглэл

¹⁸ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас №362 43, 45, 62, 66-р тал.

¹⁹ Мөн тэнд. 42, 44, 59, 61, 64, 65, 70, 71, 73, 75, 76, 79, 83-р тал.

зүгтээ сантай их Алтай”, “Цайвар нуурын ус²⁰” зэрэг дууг судлаач Соронзонд тэмдэглүүлжээ.

- Ховд аймгийн Булган сумын “Жаргалын зам” нэгдлийн 4-р бригадын малчин, 67 настай эмэгтэй, вангийн торгууд О.Отхой 1987 оны 4-р сарын 30-нд “Сээр дээр нь ургасан сэрвэй /сэрвэн/ харгай²¹”, “Өмнө голын эх” зэрэг дууг судлаач Соронзонд тэмдэглүүлжээ.
- Ховд аймгийн Булган сумын 3-р бригадын малчин, 55 настай эмэгтэй, бэйлийн торгууд Ц.Бадам “Гүн өнгөтэй улаан”, “Бадам чихтэй халтар”, “Цагаан саарал морь”, “Зэхүүлээ сайхан зээрд²²” зэрэг дууг тэмдэглүүлсэн нь төрөлжүүлэн ангилсан эх хэрэглэгдэхүүн дунд тохиолдож байна.
- Ховд аймгийн Булган сумын “Жаргалын зам” нэгдлийн 6-р бригадын барилгачин 49 настай эрэгтэй, вангийн хошууны торгууд Я.Оргио “Бяцхан жуухай хээр²³” /;
- Ховд аймгийн Булган сумын 3-р бригадын 61 настай эрэгтэй, бэйлийн торгууд Ж.Ийшээ “Тод сайхан зултас²⁴”;
- Ховд аймгийн Булган сумын “Жаргалын зам” нэгдлийн 5-р бригадын 55 настай эмэгтэй, вангийн торгууд Ж.Зэгдээ “Булбуур өнгөтэй улаан²⁵” ;
- Ховд аймгийн Булган сумын 1-р бригадын 71 настай эрэгтэй, хошуудын торгууд Т.Санжжав “Хашин зандан хар”, “Номгон зөөлөнг сургагч ээж аав хоёр²⁶” - хадамд очих бүсгүйд зориулсан дуу ;
- 37 настай эрэгтэй, бэйлийн торгууд Р.Дамдинбазар “Нутгаа магтъя”, “Чихэндээ имтэй хээр” ;
- Ховд аймгийн Булган сумын 5-р бригадын 60 настай эрэгтэй, бэйлийн торгууд Д.Аюуш “Илийн ангир тохой”, “Бяцхан хээр морь”, “Бардам амтай халиун” ;
- Ховд аймгийн Булган сумын “Жаргалын зам” нэгдлийн 1-р бригадын малчин, 75 настай эрэгтэй, хошуудын торгууд Т.Цахиуртай “Төмөр цоргын эх²⁷” ;
- Ховд аймгийн Булган сумын 6-р бригадын малчин, 46 настай эрэгтэй, бэйлийн торгууд Р.Бат-Очир “Найман түвт сүмбэр уул”, “Саяг саяг саарал”, “Бууржийн эхэн шил²⁸”;
- Ховд аймгийн Булган сумын 5-р бригадын 30 настай эрэгтэй, бэйлийн торгууд З.Цагаанхичиг “Үзэсгэлэнт Алтай²⁹”;
- Ховд аймгийн Булган сумын 3-р бригадын малчин, 62 настай эмэгтэй, бэйлийн торгууд Ш.Түвшинбаяр “Саадаг сажлам салхи”, “Нарийн баахан ангир”, “Баахан шилийн өвс³⁰” ;
- Ховд аймгийн Булган сумын 6-р бригадын 65 настай эмэгтэй, вангийн торгууд Э.Ерөөлт 1987 оны 4-р сарын 30-нд “Зах жаргалантай эх”, “Хүжийн утаа”, “Буга биетэй халтар”,

²⁰ Мөн тэнд. 60, 63-р тал.

²¹ Мөн тэнд. 82-р тал.

²² Мөн тэнд. 72, 74, 77-р тал.

²³ Мөн тэнд. 46-р тал.

²⁴ Мөн тэнд. 56-р тал.

²⁵ Мөн тэнд. 53-р тал.

²⁶ Мөн тэнд. 57, 58-р тал.

²⁷ Мөн тэнд. 49-р тал.

²⁸ Мөн тэнд. 59, 78, 84-р тал.

²⁹ Мөн тэнд. 85-р тал.

³⁰ Мөн тэнд. 52, 54, 55-р тал.

“Дүүрэн бэлгийн адуу³¹” зэрэг дууг болон “Ээж аавдаа очих хүүгийн дуулах нь, Ээж аавдаа очих хүүхний дуулах нь, Хүүхэн хүүгээ угтаж дуулах нь, Хүү хариу дуулах нь³²” хэмээх 4 хэсэгтэй дууг судлаач Соронзонд тэмдэглүүлжээ.

- 42 настай эрэгтэй, тайжийн торгууд А.Төмөрбаатар “Булган гол”, “Саарал ямаа”;
- Ховд аймгийн Булган сумын артелийн мужаан эрэгтэй, бэйлийн торгууд С.Чойбор “Өндөр богдын орой³³”;
- Б.Орломжав “Хэнчэртийн бэд”; Ж.Даваа “Харгай сайхан хээр” домгийн хамт; Д.Монтоо “Үнэр сайтай булигаар” ; С.Данзан “Харганаар гүйсэн туулай”, “Эрээн цоохор булжмар”, “Дааган бороон унаад ирийч” ; Ц.Гомбо “Хэдрэн ихтэй газар”, “Их дэлтэй бор нь”, “Дааган дааган алаг”, “Хасар басар хоёр” ; Бадамсүрэн “Сарны холоор өнгөрсөн” ; Б.Гомбодорж “Бужиндаа” ;
- Ховд аймгийн Булган сумын 1-р бригадын 70 настай эрэгтэй, бэйлийн торгуудын дуучин Н.Замба “Эрхэм сэтгэртэй модон”, “Буурал тохойн буга³⁴”;

Ардын аман зохиолын төрөл зүйлүүд нутгийн аялгуу судлалд ихээхэн ач холбогдолтойн учир судлаачид тодорхойгүй үгийн утгыг тухайн үүсгэгчээс нь асууж тодруулан, хавсаргадаг билээ. Эдгээр ардын дууны ард ч үгсийн утгыг хавсаргасан тэмдэглэл тохиолдож байна. Тухайлбал: “Сал тохойн мод” дуунд

Сал тохойн модонд

Самрын цэцэг ургатал

Санаанд гоа байтал

Хаахнаас нь гараад ирвийч

Туурга нэвт туяатайм билээл

Тугал хар нүдтэйм билээл

Тунхай чамайгаа гэх нь л

Тогтож сууж ядав л

Гэр нэвт гэгээтэйм билээ л

Гишүүний улаан хацартайм билээл

Гэлгэр чамтайгаа гэх нь л

Гэрт сууж ядав л³⁵ хэмээн бичсэн байх бөгөөд гишүүний улаан хацарт гэдгийг модны улаан өнгөтэй гэж тайлбарлажээ. Энэ нь Жангарын туульд гардагчлан

Гэр нэвт гэгээтэй

Гишүүн улаан хацартай

Туурга нэвт туяатай

Тунамал улаан хацартай³⁶ хэмээх мөр бадагтай адил төстэй байгаагийн хувьд “Сал тохойн мод” дууг туулиас сэдэвлэсэн дуу болохыг тодотгож байна.

³¹ Мөн тэнд. 67, 68, 80-р тал.

³² Мөн тэнд. 80, 81-р тал.

³³ Мөн тэнд. 47-р тал.

³⁴ Мөн тэнд. 50, 51-р тал.

³⁵ Мөн тэнд. 44-р тал.

Мөн гишүүн хэмээн гарч буй нь модны мөчир салаа гэхээс илүүтэй гишүүнэ ургамлын иш улаан өнгөтэй байдаг тул эмэгтэй хүний хацрын улаан туяаг адилтгасан шинжтэй байна. “Ээвийн эхэн шил” дуунд нум сумыг эрхэвч хумсавч гэжээ. Газраас харвах үйлдлийг монголчууд харваа хэмээнэ. Харин морин дээрээс харвахыг намнаа гэдэг. Энэхүү харваа намнаанд нумын хөвчийг дэлэх хоёр арга байдгийн нэг нь эрхийвчилж харвах³⁷ юм. Иймд хөвчийг эрхий хуруугаараа тойруулж долоовор хуруугаар эрхий хурууны хумсны толиог түгжиж харвах уг аргаар төлөөлүүлэн нум сумыг эрхэвч хумсавч гэж нэрлэсэн байж болно. “Гүн өнгөтэй улаан” дуунд гарч буй нүүрүүхэн хэмээх үг нь махлаг тарган гэсэн утгатай аж. Тиймээс нүүр дүүрэн хэмээх хэлцийн хураасан хувилбар байх ч магадлалтай. Энэ мэтчилэн үгийн тайлбар нь судлагдахууны ач холбогдол, үнэ цэнээр арвин билээ.

Тус шинжилгээний анги нь дээр дурдсанчлан домог хууч яриа нийт 13-ыг тэмдэглэж авсан бөгөөд 1987 оны 5 сард Ховд аймгийн Булган сумын арван жилийн сургуулийн орос хэлний багш, торгууд Ж.Буяндалайн 20 гаруй жил цуглуулж эмхэтгэсэн /5 х.х³⁸-аас дээш/ материалаас “Данжаа хошууны түүх”, “Бүрэн хайрхны домог”, “Торгууд бөхийн домог”, “Торгуудын домог” зэргийг хуулбарлаж, мэргэжлийн хүмүүс үзэж хэвлүүлэх эсэх талаар санал дэвшүүлжээ. Мөн 1987 оны 4-р сарын 30-нд Ховд аймгийн Булган сумын 5-р бригадын өндөр настан, 80 настай Нохойдойн Дамбаар “Гурван хүүхдийн домог”-ийг хэлүүлэн тэмдэглэж авсан байна. Тайланд “домог нь гол төлөв уул ус, газар нутагтай холбоотой байхад хууч яриа нь зан заншил, аж төрөх ёстой холбогдож байна” хэмээн дүгнэжээ. Учир нь “Гурван хүүхдийн домог” нь Булган сумын “Алаг толгой” бригадын нутагт байдаг уулын тухай аж. Энэ домогт тэнгэрийн охид ирж гурван хүрэн уул болсон өгүүлэмж гарах тул “Хун гүнжийн домог”-той агуулга ойролцоо хэмээсэн байна. Энэ мэтчилэн “Бүрэн хайрхны домог”, “Хулст нуур”, “Даржаа хошууны түүх” зэрэгт гол төлөв уул ус, гол мөрөн үүсэн бий болсон тухай гарах ажээ.

Тус шинжилгээний анги нь ховор ном судар сурвалжлахдаа төвөд-монгол бичгийн дурсгал сэдэвт хамрагдах эх хэрэглэгдэхүүн материал цуглуулах арга зүйг голлон баримталж, захчин, торгууд, өөлд, мянгадын хүрээ хийдэд сууж байсан хүмүүстэй уулзан тухайн сүм хийдийн түүх домгийг нь яриулжээ. Ингэхдээ Ховд аймгийн Булган сумын төвд Данзан, Гааваа зэрэг өвгөчүүлтэй уулзаж торгуудын Бэйлийн хүрээ, Тайжийн хүрээ, Хошуудын хүрээ, Вангийн хүрээний үүсэл гарлаас товч тэмдэглэсэн бөгөөд нандигнан хадгалж буй ном судрын тоймыг нь ч үзжээ. Ихэвчлэн их хөлгөн судрууд, олон тооны Алтангэрэл, Жадамба, Сундуй, Банзрагч, мөн газар ус, Алтайгаа магтсан хийгээд, бусад тахилгатай уулын сан сэржмийн жижиг хэмжээний ном судар хадгалагдаж байснаас шинжилгээний ангийнхан “Алтай уулсын сан”-гийн зарим хэсгийг хуулан авсан байна.

³⁶ Загдсүрэн У нар., *Жангарын туульс*. Ред Хорлоо П. УБ., ШУАХ, 1968.

Халх ардын тууль. Ред Хорлоо П. УБ., ШУАХ, 1967. 13-аас 63-р тал.

*1966 онд Говь-Алтай аймгийн Тайшир сумын туульч Өлзийн Думаас сурвалжлан бичсэн “Богд ноён Жангар” туулийн хатныг магтсан хэсэгт гарч байна.

³⁷ Алтанхуяг Н., *Намнаа сэтгүүл*. Цуврал №1. Ред Билгүүнчимэг М. УБ., 2022. 43-р тал.

³⁸ хэвлэлийн хуудас

Харин Гааваа гуай Булган сумын торгууд нарын тахидаг “Бүрэнхайрхан уулын сан”-г тус ангийнханд өгчээ. “Алтай уулсын сан”-д эртний Зүүнгарын торгуудын Ижил мөрөн, Зайраар нутаглаж байсныг батлах баримт болох тэр нутгийн газар усны нэрийг дурдаж магтсан байна. Үүнд, Ижил мөрөн, Алтай ээж, Ховог сайр, Эмээл зайр, Бор тал, Илийн богд, Алаг уул, Булган Чингэл, Цагаан гол гэх зэргээр дурдсан нь торгуудын гарал үүслийг улируулан судлахад нэмэр хандив болох билээ. Торгуудын түүх, гарал үүсэлтэй холбогдох яриа тэмдэглэлийг сийрүүлбэл, “Торгуудын хүрээ хийдийн тухай - Бэйлийн хүрээ, Тайжийн хүрээ, Хошуудын хүрээ”, “Вангийн хошуу хүрээ”, “Торгууд таван сумын тухай - Ван, Бэйс, Тайж, Авж, Багшийн сум” зэрэг болно. Мөн Ховд аймгийн Булган сумын 5-р бригадын 95 настай эрэгтэй, вангийн хошуудын дууч, ерөөлч Магсарын Пүрэвжалын тэмдэглэлээс бэйлийн торгуудын “Хундаганы ерөөл”, “Торгуудын хурдан морины магтаал /цол”, вангийн торгуудын “Тэрийн ерөөл” зэргийг 1987 оны 4-р сарын 30-ны өдөр хуулбарлажээ.

Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй торгууд судлалд хамаарах дээр дурдсан эх хэрэглэгдэхүүнүүдийг нэгтгэн дүгнэж үзвэл, Хэл зохиолын хүрээлэнгээс 1952-1992 оны хооронд Ховд аймгийн Булган сумын нутгаар 1958, 1965, 1977, 1987 онуудад хээрийн шинжилгээний 4 анги явж ажилласан байна. Торгуудын судлалд хамаарах 2 тууль, 20 орчим домог хууч яриа, 2 тахилгын сан, 3 ерөөл магтаал, давхардсан тоогоор 96 дуу, нийт 120 орчим судалгааны эх хэрэглэгдэхүүнийг сурвалжлан цуглуулжээ. Үүнээс давхардаагүй тоогоор торгуудын 91 ардын дууг тэмдэглэсэн бөгөөд Бууржийн эхэн шилд, Саяг саяг саарал, Хилэн сайхан хар, Цагаан саарал морин, Эрвэн жороо бор хэмээх 5 дуу л давхардсан хувилбараар бичигджээ. Мөн торгуудын өвлөн уламжлагч, вангийн торгуудын дууч М.Пүрэвжал гуайн тэмдэглүүлсэн Жангарын туулийн нэгэн бүлэг, ардын 20 орчим дуу нь судалгааны үнэт чанараа хадгалсан хэвээр байна. Бичлэг үүсгэгч нараас хамгийн олон дууг хошууд торгуудын дууч М.Пагма гуай тэмдэглүүлсэн нь торгууд түмэнд ая дуу, бий биелгээний сан арвин байдгийн илрэл билээ.

*Билгүүнчимэг М., *ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй торгууд судлалд хамаарах эх хэрэглэгдэхүүний тойм*. Торгуудын түүх, шашин, өв соёл олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2023. 1: 150-161.